



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/44/НА-СТА-ТШЗ

<p>Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyо@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Ауд. 02. 23 № 334

танай _____-ны № _____-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Э.ЭНХТУУЛ

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 заалтууд, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Иргэдэд дэмжлэг үзүүлж олгосон зээлийн эргэн төлөлтийн авлагын 233.4 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй;

Хугацаа хэтэрч, он удаан жил болсон найдваргүй 973.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;

Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны бүрдэл дутуу болон бүрдэлгүй баримтаар 23.6 сая төгрөгийн ажил гүйлгээ бүртгэсэн;

Бараа материалын 47.6 сая төгрөгийн тайланг нэр төрлөөр тайлагнаагүй, анхан шатны баримт тайлагналын шаардлага хангаагүй;

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

2015 оноос хэрэгжиж эхэлсэн, иргэнд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2-4 жилийн хугацаатай, хүүгүй, барьцаагүй 4,974.2 сая төгрөгийн зээлийг 1350 иргэнд олгосон. Тайлант онд авлага барагдуулах үйл ажиллагааг 2 үе шаттай хэрэгжүүлж, зээл авсан иргэдэд мэдэгдэл хүргүүлэх, сонсох ажиллагаа хийх, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, эрэн сурвалжлах, шүүх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хийсний үр дүнд нийт 775.7 сая төгрөгийг төлүүлж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт ороогүй батлагдсан 9 орон тооноос 3 орон тоо дутуу ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнаж, үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
33	АВЛАГА	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	2,984,189,402.00	3,650,435,944.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	1,840,971,048.00	2,459,993,210.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	488,976,925.00	582,383,224.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	300,482,019.00	397,843,073.00
33717	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	214,590,102.00	188,545,102.00
33720	Аймаг, хийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	129,729,308.00	15,591,335.00
33730	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	9,440,000.00	6,080,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	50,115,000.00	400,086,890.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
512	Хуримтлагдсан үр дүн	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,285,786,028.00	2,984,189,402.00
51220	Тайлант үеийн үр дүн	748,518,374.00	1,066,333,432.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,034,304,402.00</u>	<u>4,050,522,834.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,769,402,000.00	2,858,852,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,769,402,000.00	2,858,852,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	840,000.00	25,300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	840,000.00	25,300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,000.00	25,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,768,562,000.00	2,833,552,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,768,562,000.00	2,833,552,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,768,562,000.00	2,833,552,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,020,883,626.00	1,792,518,568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,020,883,626.00	1,792,518,568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,200,000.00	76,021,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,200,000.00	76,021,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,200,000.00	76,021,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,018,683,626.00	1,716,497,568.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	861,948,817.00	930,246,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	861,948,817.00	930,246,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	484,413,183.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	484,413,183.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	840,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	840,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	671,481,626.00	786,251,368.00

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	671,481,626.00	786,251,368.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	748,518,374.00	1,066,333,432.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	748,518,374.00	1,066,333,432.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,769,402,000.00	2,858,852,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	840,000.00	25,300,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	840,000.00	25,300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	840,000.00	25,300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	840,000.00	25,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,768,562,000.00	2,833,552,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,768,562,000.00	2,833,552,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,768,562,000.00	2,833,552,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,441,466,626.00	3,441,466,626.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,441,466,626.00	3,634,605,458.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,200,000.00	75,897,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,200,000.00	75,897,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,200,000.00	75,897,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,439,266,626.00	3,558,707,758.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,281,948,817.00	2,372,369,500.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,281,948,817.00	2,372,369,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	485,253,183.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	485,253,183.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	672,064,626.00	1,186,338,258.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	672,064,626.00	1,186,338,258.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(672,064,626.00)	(582,614,626.00)
14	Бусад эх үүсвэр	672,064,626.00	775,753,458.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	672,064,626.00	775,753,458.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	672,064,626.00	775,753,458.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,305,327,028.00	2,305,327,028.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-19,541,000.00	-19,541,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,285,786,028.00	2,285,786,028.00
Тайлант үеийн үр дүн	748,518,374.00	748,518,374.00
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,034,304,402.00	3,034,304,402.00
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,034,304,402.00	3,034,304,402.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-50,115,000.00	-50,115,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,984,189,402.00	2,984,189,402.00
Тайлант үеийн үр дүн	1,066,333,432.00	1,066,333,432.00

2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,050,522,834.00	4,050,522,834.00
--	------------------	------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,853,552,000.00	2,448,267,200.00	385,284,800.00	86.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,833,552,000.00	2,448,267,200.00	385,284,800.00	86.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	119,750,000.00	75,897,700.00	43,852,300.00	65.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	119,750,000.00	75,897,700.00	43,852,300.00	65.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	119,750,000.00	75,897,700.00	43,852,300.00	65.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,713,802,000.00	2,372,369,500.00	341,432,500.00	87.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,713,802,000.00	2,372,369,500.00	341,432,500.00	87.42
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,713,802,000.00	2,372,369,500.00	341,432,500.00	87.42
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,853,552,000.00	2,473,567,200.00	379,984,800.00	86.78
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,833,552,000.00	2,448,267,200.00	385,284,800.00	86.49
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,833,552,000.00	2,448,267,200.00	385,284,800.00	86.49
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН	20,000,000.00	25,300,000.00	(5,300,000.00)	126.50

	ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	25,300,000.00	(5,300,000.00)	126.5 0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 49,532.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдлийг 49,532.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Эдгээр нь УСНББОУС-20 холбоотой талуудын тодруулга, УСНББОУС-24 төсвийн мэдээллийн толилуулга болон санхүүгийн тайлангийн “Толилуулга”, “Иж бүрэн”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 1,277,990.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 1,020,954.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 257,035.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1: 2015 оноос хэрэгжиж эхэлсэн, иргэнд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн хугацаа хэтэрсэн 973,324.3 мянган төгрөг авлага байгаа нь хөтөлбөрт зээлийн үр өгөөж хангагдахгүй, төсөв хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдах нөхцөл бий болгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтыг хэрэгжүүлээгүй, “Үнэлгээ ба хуваарилалт”, “Иж бүрэн байх” “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт-2: Бараа материалын тайланг нэр төрлөөр тайлагнаагүй 46,936.0 мянган төгрөг, эд хариуцагчийн тайлан нь гар бичмэлээр баллаж, цохолсон дүгнэж нэгтгээгүй, анхан шатны баримтын шаардлага хангаагүй, шатахуун зарцуулалтын тайланг анхан шатны баримт болон дансны журналын бичилттэй тулган шалгахад 694.3 төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь бараа материалын тайлан буруу илэрхийлэгдэх, шатахууныг хяналтгүй зарцуулах үр дагавар бий болгосон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт “Иж бүрэн байх” “Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт-3: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээших орлогын 339,689.0 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 487,457.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, шийдвэрийн 501,541.0 мянган төгрөгийн 32 мэдээлэл дутуу байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг ханган, мэдээллийг хугацаандаа ил тод бүрэн тусгаж, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт-1: Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 23,620.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж зардалд тусгасан. Энэ нь төсөв хяналтгүй зарцуулагдах үр дагавар бий болгосон ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг хэрэгжүүлээгүй, "Иж бүрэн байх" "Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, хөтөлбөр арга хэмжээнд төсөв баталж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Зээлийн эргэн төлөлтийн нийт 4,050,522.8 мянган төгрөгийн авлагаас 233,415.6 мянган төгрөгийн авлага тооцоо нийлсэн актгүй нь санхүүгийн тайлагнал үнэн зөв илэрхийлэгдээгүй байх, авлагын үлдэгдэл баталгаажигдахгүй байх үр дагаврыг бий болгох ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалт хэрэгжээгүй, "Иж бүрэн байх" "Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрдүүлж, бүртгэлд тусгаж тайлагнаж байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруу-лаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдлийг дутуу тайлагнасан	1	49.5			1	49.5	1	49.5				
Дүн	1	49.5			1	49.5	1	49.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зээлийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл байна.	1	973.3			1	973.3						
Бараа материалын тайланг нэр төрлөөр тайлагнаагүй, гар бичмэлээр баллаж, цохолсон дүгнэж нэгтгээгүй, анхан шатны баримтын шаардлага хангаагүй	1	47.6			1	47.6						
Нэмэлт санхүүжилтээр хэрэгжүүлсэн зарим төсөл хөтөлбөр арга хэмжээний төсвийн зарцуулалтын болон гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнэсэн актгүй, анхан	1	23.7					1	23.7				

